

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМЫН ЗӨВЛӨМЖ

### Арбитрын тухай хуулийг давж заалдах шатны шүүхэд хэрэглэх талаар

Арбитрын тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйл, 13 дугаар зүйл, 15дугаар зүйлийн 15.5-15.7, 17дугаар зүйлийн 17.4, 18дугаар зүйлийн18.2, 20дугаар зүйлийн 20.6, 33 дугаар зүйл, 40 дүгээр зүйл, 42 дугаар зүйл, 43 дугаар зүйлд зааснаар арбитрын хэрэг, маргааныг арбитраар шийдвэрлэх ажиллагааны зарим тодорхой үе шатанд давж заалдах шатны шүүх оролцох шинэ зохицуулалт хуульчлагджээ.

Шүүхийн тухай хуулийн 15дугаар зүйлийн 15.3,15.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн танхимаас Аймаг,Нийслэлийн давж заалдах шатны шүүхүүдэд ЗӨВЛӨХ НЬ:

1. Давж заалдах шатны шүүх /цаашид Шүүх гэх/ зөвхөн дараах тохиолдолд арбитрын ажиллагаанд оролцоно:
  - (i) Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг шүүх\_баталгаажуулах (Арбитрын тухай хуулийн 13 дугаар зүйл)
  - (ii) Арбитрчаа томилж чадаагүй тохиолдолд аль нэг тал нь арбитрч томилуулах хүсэлт гаргасан; (15.5 дугаар зүйл,15.6)
  - (iii) арбитрч томилох журмыг зөрчсөн эсхүл арбитрчийг томилох үүргээ биелүүлээгүйгээс арбитрч томилуулах хүсэлт гаргасан (15.7 зүйл)
  - (iv) арбитрчаа татгалзан гаргаж чадахгүй байгаа тохиолдолд аль нэг тал нь арбитрчийг татгалзан гаргаж өгөх хүсэлт гаргасан; (17.4 зүйл)
  - (v) арбитрчийн эрх, үүрэг дуусгавар болсонтой холбоотой маргааныг шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргасан; (18.2 зүйл)
  - (vi) талууд арбитрын харъяаллын талаар болон арбитрын эрх хэмжээний талаар гомдол гаргасан; (20.6 зүйл)
  - (vii) нотлох баримт албадан гаргуулахаар хүсэлт гаргасан; (33 зүйл)
  - (viii) талууд арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлт гаргасан; (40 зүйл)
  - (ix) талууд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгүүлэх хүсэлт гаргасан; (42 зүйл)
  - (x) арбитрын шийдвэрийг баталгаажуулах, гүйцэтгэхээс татгалзах зэрэг хуульд заасан асуудлаар шүүх арбитрын ажиллагаанд оролцоно; (43 зүйл)

Эдгээрээс өөр тохиолдолд шүүх арбитрын ажиллагаанд оролцохгүй.

Арбитрын тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д заасны дагуу Байнгын арбитр нь мөн хуулийн 15дугаар зүйлийн 15.5-15.7,

17дугаар зүйлийн 17.4, 18дугаар зүйлийн18.2, 20дугаар зүйлийн 20.6-д заасан маргааныг шүүхээс өөр этгээдээр шийдвэрлүүлэхээр дүрэмдээ зааж болно.энэ тохиолдолд тухайн этгээдийн гаргасан шийдвэр эцсийн байна. Байнгын арбитрын дүрэмд дээрх асуудлыг өөр этгээдээр шийдвэрлүүлэхээр заасан тохиолдолд шүүх оролцохгүй. Шүүх Арбитрын тухай хуулийн дээрх заалтад заасан асуудлыг шийдвэрлэхдээ шүүхийн тогтоол,шүүгчийн захирамж гаргана. Арбитрын тухай хуулийн 15дугаар зүйлийн 15.5-15.7, 17дугаар зүйлийн 17.4, 18дугаар зүйлийн18.2, 20дугаар зүйлийн 20.6-д шүүхийн шийдвэр эцсийн байхаар заажээ.

## 2. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах

Арбитрын ажиллагаа эхлэхээс өмнө буюу арбитрын ажиллагааны явцад талууд арбитраас гаргах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахаар эд хөрөнгө битүүмжлэх, данс хаах, хариуцагчийг тодорхой үйлдэл хийхийг хориглох зэрэг арга хэмжээ авахуулах хүсэлт шүүхэд гаргана. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахаар гаргасан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ.

## 3.Шүүхээс арбитрч томилоход туслалцаа үзүүлэх

### 3.1. Шүүх дараах тохиолдолд арбитрчийг томилно:

- а. талууд арбитрч томилох тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өөрийн талын арбитрчийг томилоогүй.
- б. томилогдсон арбитрчид даргалагч арбитрчийг 30 хоногийн дотор томилж чадаагүй
- в. арбитрч томилох журмыг аль нэг тал зөрчсөн
- г. Талууд тохиролцсон журмынхаа дагуу арбитрчийг томилж чадаагүй
- д. байнгын арбитрын дүрэмд заасан эрх бүхий этгээд арбитрч томилох үүргээ биелүүлээгүй
- е. хэрэг шийдвэрлэх арбитрчийн тоо нэг байхаар тохиролцсон бөгөөд сонирхогч тал арбитрч томилуулах хүсэлт гаргасан

### 3.2. Шүүх тухайн этгээдийг арбитрчаар томилохдоо дараах шалгуурыг анхаарна:

- а. арбитрын тухай хууль болон бусад хуулиар арбитрчаар ажиллахыг зөвшөөрсөн
- б. арбитрчаар ажиллах цагийн боломж
- в. тухайн хэрэг маргааны онцлогийг ойлгох тухайн салбарын талаар зохих мэдлэгтэй

- г. талуудын тавьсан шалгуурыг тухайн арбитрч хангаж байгаа эсэх
- д. тухайн хэргийг бие даан, хараат бусаар шийдвэрлэх чадвар

3.3. Шүүх арбитрчийг томилохдоо тухайн арбитрын арбитрч нарын нэрсийн жагсаалт, товч намтрыг авч судалж үзнэ.

3.4. Талууд арбитрын хэлэлцээрт арбитрчид тавих шалгуурыг заах эрхтэй. Жишээ нь арбитрчийн хэлний мэдлэг, нас, мэргэжил, мэргэшлийн шалгуур тавьж болно. Хэрэв ийм тохиролцоо байх тохиолдолд шүүх түүнийг харгалзана.

#### 4. Шүүх арбитрчийг татгалзах тухай хүсэлтийг шийдвэрлэх:

Шүүх дараах тохиолдолд арбитрчийг татгалзан гаргах асуудлыг шийдвэрлэнэ. Үүнд:

- талуудын тохиролцсон журмын дагуу арбитрчийг татгалзаж гаргаж чадаагүй бол
- арбитрчийг татгалзан гаргах нөхцөл байдал илэрснийг мэдмэгцээ буюу эсхүл тухайн маргаанаар ажиллагаа явуулах арбитрын бүрэлдэхүүн бүрэн бүрдснийг мэдснээс хойш 15 хоногийн дотор арбитрчийг татгалзан гаргах хүсэлтийг арбитрын бүрэлдэхүүнд гаргасан боловч бүрэлдэхүүн арбитрчийг татгалзаагүй шийдвэр гаргасан.

4.1. Шүүх арбитрчийг татгалзахдаа дараах үндэслэл байгаа эсэхийг хянана:

- а. Арбитрч тухайн маргааныг бие даан, хараат бусаар шийдвэрлэж чадах эсэхэд нь эргэлзээ төрүүлэх илэрхий нөхцөл байдал байгаа эсэх

Талууд арбитрчийг татгалзах хүсэлт гаргах замаар арбитрын ажиллагааг сунжруулах явдал гардаг тжл шүүх дээрх асуудлыг нэн даруй шийдвэрлэж байх нь зүйтэй.

#### 5. Шүүх арбитрчийн эрх, үүрэг дуусгавар болсонтой холбоотой маргааныг шийдвэрлэх бөгөөд дараах тохиолдолд арбитрчийг татгалзаж оронд нь өөр арбитрч нөхөн томилно.

- а. арбитрч алив бодит шалтгааны улмаас үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болсон
- б. арбитрч байхаас өөрөө санаачилгаараа татгалзсан

#### 6. Шүүх арбитрын бүрэлдэхүүний эрх хэмжээний талаарх шийдвэрт талуудын гаргасан гомдлыг хянан шийдвэрлэнэ.

6.1. Арбитрын бүрэлдэхүүн дараах асуудлыг урьдчилан шийдвэр гаргах эсхүл энэ тухай үндсэн шийдвэрт тусгах замаар шийдвэрлэнэ:

- а. тухайн маргаан арбитрын харъяаллын маргаан эсэх
- б. арбитрын хэлэлцээр бий эсэх
- в. арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр эсэх

6.2. Талууд арбитрын бүрэлдэхүүний энэ шийдвэртэй санал үл нийлвэл энэ тухай гомдлоо шүүхэд гаргаж шийдвэрлүүлж болно.

Арбитрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн дагуу талууд маргааны харъяаллын талаар гомдол гаргахаар бол үндсэн нэхэмжлэлд тайлбар гаргахаасаа өмнө тухайн арбитрын бүрэлдэхүүнд уг гомдлыг гаргана. Хэрэв үндсэн нэхэмжлэлд тайлбар гаргахаасаа өмнө тухайн арбитрын бүрэлдэхүүнд гомдлоо гаргаагүй бол гомдол гаргах эрхээ алдана.

#### 7. Арбитрын хэлэлцээрийг дараах тохиолдолд байгуулсан гэж үзнэ:

- а. талуудын гэрээ арбитрын тухай заалттай
- б. талууд арбитраар маргаанаа шийдвэрлэхээр гарын үсэг зурсан баримт үйлдсэн
- в. талууд арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхээр тохиролцсныг нотлох хоорондоо солилцсон захидал харилцаа
- г. маргаан гарсны дараа арбитраар маргаанаа шийдвэрлэхээр тохиролцсон тохиролцоо зэрэг болно.

#### 8. Арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр эсэх

Арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлоход дараах асуудлыг анхаарна.

- тухайн хэлэлцээрийг эрх зүйн чадамж бүхий этгээд байгуулсан эсэх
- тухайн хэлэлцээрээр арбитраар маргаан шийдвэрлэхээр тохиролцсон эсэх зэргийг анхаарч үзнэ.

#### 9. Шүүх нотлох баримт гаргахад туслалцаа үзүүлнэ.

Арбитрын бүрэлдэхүүн эсхүл түүний зөвшөөрснөөр аль нэг тал тухайн маргаантай холбоотой нотлох баримт гаргуулахаар шүүхэд хүсэлт гаргана. Энэ тохиолдолд шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд уг хүсэлтийг шийдвэрлэнэ.

#### 10. Шүүх арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай талуудын гаргасан хүсэлтийг шийдвэрлэх

Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т заасан үндэслэлүүдээр шүүх “Шүүхийн тогтоол” гаргаж, Арбитрын шийдвэрийг хүчингүй болгоно.

11. Шүүх арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг хүлээн авснаар түүнийг судлан үзэж, шаардлагатай тохиолдолд тухайн маргааныг шийдсэн арбитрын бүрэлдэхүүн ,эсвэл бусад талуудаас лавлагаа, тайлбар авч болно.

12. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох зөрчил гаргасан бөгөөд түүнийг арбитрын бүрэлдэхүүнээр өөрөөр нь засуулах хүсэлтийг аль нэг тал гаргасан бол шүүх арбитрын шийдвэрийг хянан ажиллагааг тодорхой хугацаа тогтоон түдгэлзүүлж болно. Арбитрын бүрэлдэхүүн шүүхээс тогтоосон хугацаанд зөрчлийг засаагүй бол давж заалдах шатны шүүх түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгож, давж заалдах гомдлыг хэлэлцэн шийдвэр гаргана.

### 13. Шүүх арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгүүлэх

Шүүх арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгүүлэх хүсэлт гаргасан зэрэг хуульд заасан асуудлаар арбитрын ажиллагаанд оролцоно.

13.1 Арбитрын шийдвэрийг холбогдох тал биелүүлээгүй бол нөгөө тал уг шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргаж болно.

13.2 Арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлт гаргасан тал дараах баримтыг шүүхэд өгнө:

1. шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлт
2. арбитрын шийдвэрийн эх хувь эсвэл түүний зохих журмын дагуу /тухайн арбитрын шийдвэр гарсан улсын хуулийн дагуу/ гэрчилсэн хуулбар
3. арбитрын хэлэлцээрийн эх хувь, эсхүл түүний зохих журмын дагуу /тухайн арбитрын шийдвэр гарсан улсын хуулийн дагуу/ гэрчилсэн хуулбарыг хавсаргана.

14.Гадаад хэлээр бичигдсэн арбитрын шийдвэр, арбитрын хэлэлцээрийг монгол хэл дээр орчуулж, гэрчлүүлэн арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлтэд хавсаргана.

Арбитрын тухай хуулийн 2дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн “Монгол улсын олон жлсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн заалтын дагуу гадаад арбитрын шийдвэрийг 1958 оны “Гадаад Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай” Нью Йоркийн конвенцийг баримталж биелүүлнэ.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМЫН

ТЭРГҮҮН ШҮҮГЧ

Р.ЖАМЪЯАНЧОЙЖИЛ